



МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 21 өдөр

Дугаар 353

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Эмчилгээний чанарын хяналтын асуудал хариуцсан улсын ахлах байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар хавсралт ёсоор тус тус батлахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт зөвшөөрсүгэй.

2. Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, дунд хугацааны зорилтот хөтөлбөрт дэвшүүлсэн төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

3. Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг албажуулах, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Ажлын албаны (В.Жавзан)-д даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу томилогдон ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчийн хууль ёсны эрх ашгийг хангаж, эрх зүйн байдлыг дордуулахгүй байх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт зөвлөсүгэй.

ДАРГА



Л.ЦЭДЭВСҮРЭН

24000859